

## ЖАЙКА-ийн Монгол дахь Төлөөлөгчийн газрын мэдээллийн хуудас. 2018 оны 3 сарын дугаар

### Тэргүүн Мэдээ

#### "Инженер, технологийн дээд боловсрол" төслийн хүрээнд Япон улсад суралцах 96 оюутанд батламж гардуулав.



Батламж гардан авсан оюутнууд

3 сарын 14-ний өдөр “Инженер, технологийн дээд боловсрол” төслийн хүрээнд Японд суралцах багш, оюутнуудад батламж гардуулах ёслол болов. Япон хэлээр байгалийн ухаан ба математикийн хичээлийг эрчимтэй үзсэний үр дүнд Японы их дээд сургууль болон коосэнд элсэх шалгалтад тэнцсэн оюутнууд ийнхүү Японд улсын сургуулиудад механик инженер, барилга, архитектурын чиглэлээр суралцахаар мордох гэж байна.

Мөн энэхүү төслийн хүрээнд Японы их дээд сургуулийн багш нар Монгол улсын ШУТИС-ийн инженерийн чиглэлийн сургалтын программыг сайжруулахад дэмжлэг үзүүлж байгаа юм.

### Улс төр, эдийн засгийн чиг хандлага

#### Татварын ерөнхий хуульд нэмэлт өөрчлөлт оруулна.

Монгол улсын засгийн газар 2018 оны 4 сард эхэлсэн УИХ-ын хаврын чуулганаар Татварын ерөнхий хуулийн нэмэлт өөрчлөлт зэргийг багтаасан татварын хуулийн шинэчлэлийг санал болгох гэж байна. Татварын ерөнхий хуулийн нэмэлт өөрчлөлтийн зорилго нь татварын баазыг өрөгжүүлэх, татвар төлөгчийн эрхзүйн хариуцлагыг бэхжүүлэх, олон улсын татвар ногдуулалтын системийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, татварын засаглалын ил тод байдлыг хангах явдал бөгөөд олон нийтийн санал асуулгаар иргэдээс 5600 санал, шүүмжлэл ирэх зэргээр ард нийтийн сонирхолыг ихээхэн татсан асуудал болоод байгаа юм. ЖАЙКА олон улсын татвар ногдуулалтын системийг боловсронгуй болгох, боловсон хүчин сургах, татварын өрийг барагдуулах чиглэлээр техникийн хамтын ажиллагааны төсөл хэрэгжүүлж байгаа бөгөөд ЖАЙКА-ийн мэргэжилтнүүд хуулийн төсөл боловсруулахад өргөн хүрээнд зөвлөгөө өгөн хамтран ажиллаж байгаа болно.

### Төслийн хэрэгжилт

#### Өвсний үндэс “Дорноговь аймгийн ус ариутгах татуургын менежментийн чадавхийг сайжруулах төсөл”-н 3 жилийн үйл ажиллагаа өндөрлөв.



Инженерүүдэд зааварчилгаа өгч байгаа нь

Дорноговь аймгийн бохир усны шугам хоолойн байгууламж хангалтгүй байдаг. Түүнчлэн 2015 онд бохир ус цэвэрлэх байгууламж шинээр байгуулагдсан боловч түүний ашиглалт үйлчилгээг явуулах менежментийн ур чадвар дутагдаж байсан. 3 жилийн хугацаатай энэхүү төслийн хүрээнд бохир ус ариутгах татуургын менежментийн чадавхийг сайжруулах болон тухайн орон нутгийн усны орчинг сайжруулах зорилгоор инженер техникийн заавар өгөх, Японд сургалтанд хамруулах, усны орчны боловсролын сургалт зохион байгуулах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлсэн бөгөөд 2018 оны 3 сард үйл ажиллагаа өндөрлөв. Төслийн баг сүүлийн удаа тус аймагт ажиллах үеэр Дорноговь аймгийн засаг дарга төслийг гүйцэтгэсэн Шизуока мужийн төлөөлөлд гүн талархал илэрхийлэв.

#### Дархан Уул аймагт биед авч буй давсны хэмжээг зөв тодорхойлох арга зааж өгөв.



24 цаг шээс хуримтлуулах аргын зааварчилгаа өгч

3 сарын 14,15-ны өдөр өвсний үндэс ТХА “Дархан аймагт амьдралын буруу хэвшлээс үүдэлтэй өвчлөлийн эрүүл мэнд, эмнэлгийн тусламжийг сайжруулах төслийн хүрээнд ( хэрэгжүүлэгч байгууллага: Мито Сайсэйкай Нэгдсэн Эмнэлэг) урьдчилан сэргийлэх эпидемиологийн мэргэжилтний зүгээс эмч, сувилагч нарт биед авч буй давсны хэмжээг зөв тодорхойлох 24 цагийн турш шээс хуримтлуулах аргын талаар сургалт явууллаа. Монголд хоолны давсны хэрэглээ их байгаагаас шалтгаалсан цусны

даралт ихсэх өвчлөл асуудал болж байгаа ба сургалтанд оролцогчид нэг өдрийн сургалтаар өөрийн шээсийг хуримтлуулан хэмжих цуврал аргад суралцлаа. Цаашид суралцсан аргаар дамжуулан иргэдэд давсны хэрэглээг багасгах талаар сургалт явуулахад ашиглахаар төлөвлөж байна.

## “Шударга өрсөлдөөний орчныг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд Япон улсад сургалт зохион байгуулав.



Сургалтын дараах үнэлгээний хурлын үеэр

2 сарын 25-наас 3 сарын 2-ны өдөр ТХА “Шударга өрсөлдөөний орчныг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд Японы шударга худалдааны хорооны дэмжлэгээр Японы монополийг хориглох хуулийн хэрэгжилтийн байдал, зах зээлийн судалгааны арга ба түүнийг хэрхэн ашиглах талаар Япон улсад сургалт зохион байгуулж, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын байцаагч зэрэг нийт 15 хүн оролцов. Оролцогчид “Зах зээлийн судалгааны аргыг сайн ойлголоо. Монголын нөхцөлд хэрхэн ашиглаж болохыг нь судалж үзмээр байна.” хэмээн сэтгэгдэлээ илэрхийлж байсан зэргээс үзэхэд энэхүү сургалт нь ихээхэн сэдэл өгсөн арга хэмжээ болсон байна.


## Орон сууцны бодлогын талаарх семинар болов.



Танилцуулга хийж буй мэргэжилтэн Нагаяма

3 сарын 22-ны өдөр ТХА “Улаанбаатар хотын ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх чадавхийг бэхжүүлэх төслийн” үйл ажиллганы хүрээнд орон сууцны бодлогын талаар семинар зохион байгуулав. Энэ өдрийн семинарт БХБЯ, УБ хот, арилжааны банканы төлөөлөл оролцож, орлого багатай иргэдийг орон сууцаар хангах арга зам ба орон сууцны санхүүжилт ямар байх ёстой талаар нухацтай хэлэлцэв. Цаашид орон сууцны талаар баримтлах бодлогын чиглэлийг авч үзэхэд хэрэг болохуйц семинар боллоо хэмээн оролцогчдын талархалыг хүлээсэн ач холбогдолтой арга хэмжээ болов

## “Мал эмнэлэг, мал аж ахуйн салбар дахь хүний нөөцийг чадавхжуулах төслийн” мэргэжилтэн Үмэмура “Хоккайдогийн нийгэмд хувь нэмэр оруулсаны төлөө шагнал” хүртэв.



Мэргэжилтэн Үмэмура (зүүн) болон Хоккайдо мужийн дэд захирагч Цүжи (голд)

3 сарын 2-ны өдөр ТХА-ны төслийн мэргэжилтэн Такаши Үмэмурад (Хоккайдогийн Их сургуулийн хүндэт профессор) Монгол улсын мал эмнэлгийн салбарын арга зүйн чадавхийг дээшлүүлэх, хүний нөөцийг хөгжүүлэхэд оруулсан үнэтэй хувь нэмрийг нь үнэлэн “Хэйсэй 29 (2017) оны Хоккайдогийн нийгэмд хувь нэмэр оруулсаны төлөө шагналыг” олгов. Мэргэжилтэн Үмэмура нь 2014 онд төсөл эхэлсэн цагаас Монгол улсын ХААИС-ийн Мал эмнэлгийн сургуулийн багш нар болон малын эмч нарын хүний нөөцийг хөгжүүлэх ажилд хүчин зүтгэж ирснийхээ төлөө тус их сургуулийн хүндэт профессор цолоор шагнуулсан бөгөөд түүний хувь нэмрийг Монгол, Япон талын аль аль нь ийнхүү үнэлсэн байна.

## Бусад төсөл

3 сарын 19-ний өдөр урт хугацааны мэргэжилтэн Тамай (Хүлэмжийн хийн тооллого хийх чадавхийг бэхжүүлэх замаар үндэсний хүлэмжийн хийн тооллогын мөчлөгийг тасралтгүй сайжруулах төсөл) ирэв.

## Сайн дурын үйл ажиллагаа

### Сайн дурын үйл ажиллагааны танилцуулга.

#### Нөхөн сэргээх эмчилгээний талаарх семинарын агуулга, үр дүнг танилцуулах сургалт



Сургалт явуулж буй байдал

Эрдэнэт хотын сайн дурын гишүүн Кавабата (2016 оны 4-р ээлж/Сувилагч) нь 2, 3-р саруудад нөхөн сэргээх эмчилгээний талаарх сургалтыг хэд хэдэн удаа зохион байгууллаа. Энэхүү сургалтын зорилго нь 2017 онд 2 удаа зохион байгуулагдсан нөхөн сэргээх эмчилгээний семинарт оролцсон хүмүүс тус семинарт суугаад өнгөрөх биш сурч мэдсэн зүйлээ бусдад зааж өгөх, дамжуулах замаар мэдлэгээ бэхжүүлэхэд оршино. Семинарын явцад зарим агуулга, арга зүйн ойлголтууд сайн бууж өгөхгүй байсан бол бусад хүмүүст зааж сургаснаар бага багаар өөрийн болгоод явах боломжтой юм.



## ЖАЙКА-ийн Сургалт төгсөгчдийн холбооны “Бүх гишүүдийн хурал” болов.



Бүх гишүүдийн хуралд оролцогсод зураг авахуулав

3 дугаар сарын 2-ны өдөр ЖАЙКА-ийн Сургалт төгсөгчдийн холбооны “Бүх гишүүдийн хурал” зохион байгуулагдаж, холбооны тэргүүн Ц.Оюунбаатар болон ЖАЙКА байгууллагын төлөөлөл, холбооны гишүүд зэрэг нийт 53 хүн оролцов. Тус хурлын үеэр 2017 оны үйл ажиллагааны тайлан болон 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг танилцуулснаас гадна сургалтын үр дүнг ажилдаа нэвтрүүлэх чиглэлээр идэвхи зүтгэл гарган ажилласан 3 хүнийг (Боловсрол, хүнсний аюулгүй байдал, гамшгаас хамгаалах чиглэлээр ажилладаг) ”Шилдэг туршлага нэвтрүүлэгч”-ээр шалгаруулж шагнал гардуулав. Дээрх 3 хүний үйл ажиллагааны талаар дараагийн дугаараас танилцуулах болно.

発行：JICA モンゴル事務所

Bodi Tower 7th Floor, Sukhbaatar Square 3, Ulaanbaatar

Tel : +976-325939, 311329 / Fax : +976-310845 / E-mail : mg\_oso\_rep@jica.go.jp